



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Зааврыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.


Гурав. Зааврын дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх програм хангамжийг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор боловсруулж, нийгмийн даатгалын хэлтсүүдэд шуурхай хүргүүлж, 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс тэтгэвэр авагчдад нэмэгдсэн тэтгэврийг олгох нөхцөлийг бүрдүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д даалгасугай.

Дөрөв. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Д.ЗОРИГТ





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОЖ БАЙГАА БОЛОН
ЦЭРГИЙН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХЭД
БАРИМТЛАХ ЗААВАР


Баримт бичгийн дугаар: ЗВР-БХСГ- . . . -2020

Баталсан: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга  Д.ЗОРИГТ

Хянасан: Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга  Ц.ГАНЦЭЦЭГ

Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын Ахлах мэргэжилтэн  С.ЯХАГВАДОРЖ

Боловсруулсан: Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн  Ө.БОДЬГЭРЭЛ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын БХСГ				

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл


Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар
6. Хариуцлага





Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2020 оны 01 дугаар сарын 28-ны өдрийн А/12
дугаар тушаалын хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОЖ БАЙГАА БОЛОН
ЦЭРГИЙН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХЭД
БАРИМТЛАХ ЗААВАР**

НЭГ. Зорилго

1.1. Энэхүү зааврын зорилго нь Засгийн газрын 2020 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 24 дүгээр тогтоолын дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэдийн тэтгэврийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр; үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр; улсын төсвөөс цэргийн алба хаасны, тэжээгчээ алдсаны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа нийт тэтгэвэр авагчид.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар), тасаг, сумын байцаагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

4.1. Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү бүртгэлийн газар.

**ТАВ. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон
цэргийн тэтгэврийн хэмжээг
нэмэгдүүлэх**

5.1. Энэ зааврын 2.1-д заасан тэтгэвэр авагчдын тэтгэврийг доор дурдсанаар нэмэгдүүлнэ. Үүнд:

5.1.1. 499 999 (дөрвөн зуун ерөн есөн мянга есөн зуун ерөн ес) төгрөг болон түүнээс доош тэтгэврийн хэмжээг 30 000 (гучин мянга) төгрөгөөр;

5.1.2. 500 000 (таван зуун мянга) болон түүнээс дээш төгрөгийн тэтгэврийн хэмжээг 25 000 (хорин таван мянга) төгрөгөөр;

5.1.3. 500 000-504 998 төгрөгийн тэтгэврийн хэмжээг 25 000 төгрөгөөр нэмэгдүүлэхэд 529 999 төгрөгт хүрэхгүй байгаа тул 529 999 төгрөгт хүргэж нэмэгдүүлэх;

5.1.4. 310 001-319 999 төгрөгийн тэтгэврийн хэмжээг 30 000 төгрөгөөр нэмэгдүүлэхэд бүрэн тэтгэврийн доод хэмжээ (350 000 төгрөг)-нд хүрэхгүй байгаа тул 350 000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэх;



5.1.5. Нийгмийн даатгалын сангаас бүрэн, түүнчлэн цэргийн бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (310 000 төг)-гээр тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг 40 000 төгрөгөөр нэмэгдүүлж 350 000 төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (270 000 төг)-гээр тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг 30 000 төгрөгөөр нэмэгдүүлж 300 000 төгрөгөөр өөрчлөх зэрэг болно.

5.2. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн дагуу тэтгэвэр нь нэмэгдсэн тэтгэвэр авагчдын тэтгэврийг 50 000 төгрөгөөр нэмэгдсэн тэтгэврийн хэмжээг нь баримтлан энэ зааврын 5.1-д заасны дагуу нэмэгдүүлнэ.

5.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2 тусдаа тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчийн хувьд тэтгэвэр тус бүрийг энэхүү зааврын 5.1-д заасны дагуу нэмэгдүүлэн өөрчилж, тэтгэвэр тус бүрт тогтоолтын хуудас хэвлэн тэтгэврийн хувийн хэрэгт хавсарган, нэгтгэн олгоно.

5.4. Нийгмийн даатгалын байгууллагад 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргаж, өргөдөл, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өгсөн иргэний хүсэлтийг нийгмийн даатгалын хэлтэс хянан хүлээн авч, тэтгэвэр тогтоолтыг мэдээллийн санд оруулсан бол тухайн иргэний тэтгэврийг энэ зааврын 5.1-д заасныг баримтлан нэмэгдүүлнэ.

5.5. Хэрэв тэтгэвэр авагч 2020 оны 01 дүгээр сард нас барсан бол энэ зааврын 5.1-д заасныг баримтлан тэтгэврийн нэмэгдлийг тооцож тухайн тэтгэвэр авагчийн ар гэрт нь тэдний өргөдөл, хүсэлтийг үндэслэн нөхөн олгоно.

5.6. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн, цэргийн бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 350 000 (гурван зуун тавин мянга)төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 300 000 (гурван зуун мянга) төгрөг байна.

5.7. Засгийн газрын 2020 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 24 дүгээр тогтоолын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврийн нэмэгдлийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно.

Зургаа. Хариуцлага

6.1. Тэтгэвэр авагчийн тэтгэврийн нэмэгдлийг буруу тооцож, тэтгэврийг зөрүүтэй олгосон тохиолдолд гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

